



## ГАЗАР ХӨДЛӨЛТИЙН ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ТАНИУЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

1.1 “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр”-ийг улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж бэлтгэх, бэлэн байдлыг хангуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах мэргэжлийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд чиглэгдэнэ.

### Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 67 дугаар тогтоолын хүрээнд газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр (2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр), 2011 оны 339, 340 дүгээр тогтоолын хүрээнд хийгдэх нэгдсэн дадлага сургууль (2024 оны 03 дугаар сарын 28-ны өдөр)-ийг төв, орон нутгийн хэмжээнд тус тус зохион байгуулна.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах алба, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, байгууллагууд, их, дээд болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, иргэд, олон нийт, айл өрхөд чиглэгдэнэ.

### Гурав. Зохион байгуулагдах үйл ажиллагаа

3.1. Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд, олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт, дадлага сургууль зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулж, тухайн шатны Засаг даргаар батлуулах.

3.2. “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөр” болон “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах” нэгдсэн дадлага, сургуулийн талаар мэргэжлийн байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан шууд ярилцлагыг аймаг, нийслэлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд хүргэх.

3.3. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор аюулгүйн талбайд цугларах дадлага, сургуульд орон нутгийн төв суурин газрын иргэдийн 40-өөс доошгүй хувийн хамруулна.

3.4. Үүрэн холбооны оператор компаниудтай хамтарч “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио”-гоор ажиллах дадлага, сургууль зохион байгуулах талаар олон нийтийн гар утсанд “Багц мессэж” мэдээлэл хүргэх.

3.5. Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах дуут дохио (сирень)-ны судалгааг гаргаж, тоог нэмэгдүүлнэ.

3.6. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээгээр иргэдэд мэдээлэл хүргэсэн байх.

3.7. Төв, орон хэмжээнд иргэдийн цугларах талбайг судалгааг гаргаж, шаардлагатай тохиолдолд тодотгол хийж, төв, суурин газрын иргэдэд таниулах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.8. Дадлага, сургуульд төв, суурин газрын төрийн болон нутгийн захиргааны байгууллага, сургууль, цэцэрлэгийн ажилтан, албан хаагчдын 60-аас доошгүй хувийг хамруулсан байна.

3.9. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх сурталчилгааны материалыг төв, суурин газрын хүн амын 20-оос доошгүй иргэдэд хүргэнэ.

3.10. Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөрлөгийг 4-оос доошгүй удаа зохион байгуулна.

3.11. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2011 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 08 дугаар захирамж “Хүн нэг бүрийн үүргэвчинд байвал зохих зүйлс”-ийн жагсаалтын дагуу бэлтгүүлэх ажлыг зохион байгуулна.

Аймгийн нэр	Газар хөдөлсөн тоо	Хагарсан, цуурсан барилгын тоо	Зарлан, мэдээлэл дамжуулах дуут (сирень) дохио	
			Одоо байгаа тоо	Нэмэгдүүлсэн тоо

#### **Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал**

4.1. Зохион байгуулсан арга хэмжээний тайланг гэрэл зургаар баримтжуулж, мэдээ ирүүлэх хүснэгтийн хамт баталгаажуулж 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Урьдчилан сэргийлэх газарт [agiunaanema@gmail.com](mailto:agiunaanema@gmail.com) цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний талаар дүнг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн дүгнэж, Монгол Улсын Шадар сайд болон

Онцгой байдлын ерөнхий газрын даргад 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн дотор танилцуулна.

4.3. Аяныг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.

---o0o---